


ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

THE THEORY OF PROVIDING PUBLIC SECURITY



Н.БАЯРМАГНАЙ

ЦЕГ-ын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын Хамгаалалтын нэгдүгээр газрын Төрийн хамгаалалтын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, ХСИС-ийн докторант

BAYARMAGNAI N.

Chief of State security division, Department of protection, Police lieutenant colonel, Doctoral Candidate of LEU

Товч утга: Олон нийтийн аюулгүй байдлын хүрээнд үүссэн нийгмийн харилцааны зарим хэсгийг эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалж, нэгэнт зөрчигдсөн бол учирсан юмуу, учирч болзошгүй хор уршгийг төрөөс арилгах арга хэмжээ авахын зэрэгцээ зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг.

Нийтийг хамарсан ямар нэгэн арга хэмжээ явагдах үед болон жагсаал, цуглааны үеэр нийгмийн хэв журам хамгаалах нь олон нийтийн аюулгүй байдалд нэгэн адил дэмжлэг үзүүлж, хүний амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас сэргийлэхээс гадна гудамж зам, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангаж, дэг журам сахиулснаар нийгмийн хэв журмыг бэхжүүлэх чухал нөхцөл болдог.

Цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт, дадлага зохион байгуулсаар ирсэн юм.

Түүнчлэн “Цагдаагийн байгууллагын тухай хууль”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн алба хаагчдаар судлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гэсэн хэдий ч нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчсөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах ажиллагаанд онол, судалгаа, дадлагын нэгдсэн ойлголт, тогтсон аргачлал үгүйлэгдсээр байна.

Abstract: The offended guilt carries legal responsibility and politics to be an arrangement to clear damage and protect some part of community, involved public security.

In the public area, protesting public order is important operation to consolidate it with some ways, which are providing road and railway traffic safety and observe the public order despite of supporting on public security and preventing threaten of life and health. The police department is conducting training and internship of ensuring the public security.

The police staff are studying and obeying law which is renewed “The law on Police” and “Operational rule of Police”.

Whatever, we need theory, research, complex practice, conception and permanent device when public order is violated.

Түлхүүр үг: Олон нийтийн аюулгүй байдал

Key word: Public security.

Нийгэм ангид хуваарилагдахын өмнө нийгмийн хэв журмыг зан заншил, уламжлалын хэм хэмжээгээр, хөдөлмөрийн хуваарилалт, хувийн өмч, анги давхарга бий болсон үеэс ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулан төрөөс хамгаалан бэхжүүлж иржээ.

Нийгмийн хэв журам нь хүний ухамсарт амьдралын үр дүн болох зан үйл, үйлдлээр илрэх хүмүүсийн хүсэл зоригийн харилцаанаас бүрэлдэн бий болно.

Нийгмийн хэв журам нь хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх бололцоог хангах, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой иргэний хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарчээ.

Монголын ард түмний эрх ашигт нийцэх, зан заншил уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэл тогтолцоо юм. Нийгмийн хэв журам нь нийгмийн хэм хэмжээнүүдээр зохицуулагдана. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээ
2. Ёс суртахууны хэм хэмжээ
3. Зан заншлын хэм хэмжээ
4. Аж төрөх ёсны хэм хэмжээ багтана.

Эрх зүйн хэм хэмжээ нь төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам ба бүх нийтээр заавал дагаж биелүүлэх төрийн албадлагаар хамгаалагдсан зан үйлийн нийлбэр цогц юм.

Ёс суртахууны хэм хэмжээ нь хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Зан заншлын хэм хэмжээ нь маш урт удаан хугацаанд хүмүүсийн ахуй амьдрал, оюун санааны уламжлал болон хадгалагдаж, давтагдсаар хүмүүсийн зан заншил болон хувирсан байна.

Аж төрөх ёсны хэм хэмжээ гэдэг нь хүний амьдрал, аж байдлыг зохицуулахад чиглэгдэнэ.

Нийгмийн хэв журмыг агуулгаар нь өргөн, явцуу утгаар авч үзнэ. Энэ нь олон нийтийн газар болон бусад орчинд хүмүүсийн дагаж мөрдөх зан үйлийн болон эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд нийгмийн хэв журмыг зөрчсөн гэж үзэж зохих хуульд заасан хариуцлагыг хүлээлгэж шийдвэрлэдэг.

Олон нийтийн газар гэдэгт: Гудамж талбай, хүн амын бүх төрлийн үйлчилгээний газар, тээврийн буудал, бусад үйлдвэр, албан газар олон нийтийн байгууллагууд, нийтийн тээврийн хэрэгсэл, орон сууц, нийтийн байр, зах зээлийн газрууд хамаарагдана. Үүнээс гадна хүнгүй газарт олон хүн цуглаж, жагсаал цуглаан хийх, уралдаан тэмцээн зохиох, даншиг наадам явуулах зэрэг нь түр хугацаагаар олон нийтийн газар болдог.

Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцааны тэр хэсэг буюу явцуу утгаар илэрхийлэгдэх олон нийтийн хэв журам нь эрх зүйн дэг журмын хүрээг тэлж тэдгээр нь хоорондоо ихээхэн хэмжээгээр давхцана.

Зан заншил, ёс суртахуун, хамтын аж байдлын хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн хэв журмын хүрээ нь эрх зүйн дэг журмын хүрээнээс гадуур оршино.

Эрх зүйн журам нь нийгмийн хэв журмын гол хэсгийг бүрдүүлж, төрөөс тогтоосон тэрхүү харилцааг зөрчигдсөн тохиолдолд эрх зүйн албадлагын хэм хэмжээг хамгаалагддаг.

Олон нийтийн аюулгүй байдал нь байгалийн гамшиг, гэнэтийн бусад осол болон зарим байгууллага хүмүүс хүрээлэн байгаа орчиндоо эд зүйл механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой иргэний нийгмийн бүтээн байгуулалтын хэрэгцээт шаардлагаас нөхцөлдөн гарсан. Монголын ард түмний ашиг сонирхолд нийцсэн, эрх зүй, зохион байгуулалт,

техникийн хэм хэмжээ, горимоор зохицуулагдаж байгаа нийгмийн харилцааны тогтолцоо юм.

Замын хөдөлгөөний болон галын аюулгүй байдал, зөвшөөрлийн тогтолцоонд ордог галт зэвсэг, хэрэгсэл авах, хүчтэй үйлчлэх хорт бодис, тэсрэх дэлбэрэх материал хадгалах, тээвэрлэх, ашиглах журам, хүн, малын гоц халдварт өвчин, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн бусад аюул зэрэгтэй холбогдон нийтийн аюулгүй байдлын хүрээ үүснэ.

Олон нийтийн аюулгүй байдлын хүрээнд үүссэн нийгмийн харилцааны зарим хэсгийг эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалж, нэгэнт зөрчигдсөн бол учирсан юмуу, учирч болзошгүй хор уршгийг төрөөс арилгах арга хэмжээ авахын зэрэгцээ зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг.

Нийтийг хамарсан ямар нэгэн арга хэмжээ явагдах үед болон жагсаал, цуглааны үеэр нийгмийн хэв журам хамгаалах нь олон нийтийн аюулгүй байдалд нэгэн адил дэмжлэг үзүүлж, хүний амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас сэргийлэхээс гадна гудамж зам, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангаж, дэг журам сахиулснаар нийгмийн хэв журмыг бэхжүүлэх чухал нөхцөл болдог.

Олон нийтийн аюулгүй байдал гэдэг үгийг Монгол хэл зүйн талаас нь авч үзвэл:

Олон нийт – Олон түмэн, нийт ард олон¹

Аюулгүй – аймаар жигшмээр юмгүй²

Байдал – аливаа юмны янз дүр төлөв, янз байдал, дүр байдал, байдал төлөв, байр байдал, шинж байдал³ гэж тайлбарласан байна.

Эндээс үзвэл олон нийтийн аюулгүй байдал гэдэг нь нийт ард олон айх, жигших юмгүй байх гэсэн шинж, төлөвийг илэрхийлж байна.

Олон оронд нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд иргэдийн оролцоог чухалчлан үздэг байна.

Тухайлбал, ОХУ-д нийгмийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг бөгөөд юуны өмнө улс орны дотоод байдлаас үүдэлтэй нийтийг хамарсан аюул, заналхийллээс хувь хүн, нийгэм, төр улс хэрхэн хамгаалагдсан түвшингээр илэрхийлэгдэнэ гэж үздэг байна.

Хүний амьдрах орчин амар тайван, нийгэм эмх журамтай, аюулгүй байх нөхцлийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг ОХУ-ын Үндсэн хууль, Холбооны хуулиуд, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, яам, газруудын тушаал, захирамж, заавар, ОХУ-ын субъектууд, орон нутгийн засаг захиргааны эрх зүйн баримт бичгүүд зэрэг олон эрх зүйн актуудаас бүрддэг.

АНУ-д Public safety гэсэн ойлголтыг олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах байгалийн болон хүний хүчин зүйлээс хамаарсан аливаа үйл явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах явдал гэж ерөнхийд нь тодорхойлдог. Гэхдээ муж улс, хот, бүс нутаг, суурин газруудад өөр өөрөөр тодорхойлон, үүндээ үндэслэн төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, мөн бусад аливаа байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх, үүргийг тодорхойлдог байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ойлголтонд холбоо, мэдээллийн

¹ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 1966. 413 дахь тал.

² Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 1966. 60 дахь тал.

³ Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ., 1966. 68 дахь тал.

систем, иргэний хамгаалалт, онцгой байдлын менежмент, хүнсний аюулгүй байдал, байгалийн гамшиг, орон байрны аюулгүй байдал, эрүүл мэнд, хувийн хамгаалалтын хэрэгсэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдлын сүлжээ, инженерийн байгууламжийн аюулгүй байдал гэх мэт асуудлыг багтаан ойлгодог ажээ.

Нөгөө талаас Public safety гэдэг нь нийгмийн гишүүн бүрийн тайван, аюулгүй байх нөхцлийг хангахтай холбоотой шинжлэх ухаан, менежмент, техникийн цогц ойлголт гэж үздэг байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Аливаа улс үндэстний оршин тогтнох үндэс нь тухайн үндэстний хүсэл эрмэлзлэлийн үр дүнд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар тогтнол байдаг. Тусгаар тогтнолын эх сурвалж нь үндэсний эрх ашгийг бүрэн хамгаалах шинж чанар бүхий Үндсэн хууль юм.

Монголчууд төрт улс, хүчирхэг гүрэн байгуулсан, үндсэн хууль буюу Их цаазыг хуульчлан тогтоосон зэрэг анхны гэх тодотголтой дэлхийн олон мянган жилийн түүхийг бүтээсэн аугаа их улс, үндэстэн гэдэгтэй хэн ч маргахгүй гэдэгт итгэлтэй байна.

Дэлхий нийтийн даяарчлалын эринд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах, хөндөгдсөн эрх ашгийг нь сэргээхэд анхаарч байгаа бол иргэд эрхээ бүрэн эдлэх хүсэл сонирхол давамгайлж байна. Иргэний энэ хүсэл сонирхол нь өөрийн үзэл бодлоо жагсаал, цуглаан зохион байгуулах хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх болсоноор илэрч байна. Гэвч аливаа хүн өөрийн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй билээ.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь иргэдийн эрх, эрх чөлөөнд хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд халдсан ажиллагаа байх бөгөөд энэ талаар авч үзэхийн тулд Монгол Улсын Үндсэн хуулийн талаар хэдэн зүйл өгүүлэх нь зүйтэй болов уу.

Монгол Улсын “Үндсэн хууль” 1924, 1940, 1960 онуудад шинэчлэн батлагдаж байсан бол 1992 оны 1 сарын 13-нд тухайн үеийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаар хамгийн сүүлийн (6 бүлэг, 70 зүйлтэй) хууль батлагдаж, тухайн оныхоо 2 сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөгджээ. Монгол Улсад зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан нийгмийг бүтээн байгуулах тогтолцооны үндсийг энэ хуулиар тавьсан юм.

Шинэ Үндсэн хууль нь парламентын засаглалтай бүгд найрамдах улсыг бий болгож, шашин шүтэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг хүний эрхүүдийг олгосон төдийгүй Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, сонгууль явуулах асуудлыг агуулсан байдаг. Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 19 дүгээр зүйлд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”⁴ хэмээн заасан байна.

Хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг Монгол Улсын Үндсэн хуультай нийцүүлэн гаргасан бусад хуулиар тогтоон өгсөн байна.

Цагдаагийн байгууллага нийтийн аюулгүй байдлыг хамгаалах нэн ялангуяа нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, нийгмийн хэв журмыг бүлэглэн

⁴ Монгол Улсын Үндсэн хууль. 1992

зөрчсөн арга хэмжээний үед үүрэг гүйцэтгэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн байгууллагын тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай, Онц байдлын тухай зэрэг олон хуулийг чанд мөрдөн ажиллах шаардлага зүй ёсоор тавигддаг. Тухайлбал:

- Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хүрээнд доор дурдсан эрх хэмжээг хэрэгжүүлнэ. 11.1.7. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх.”⁵ гэж цагдаагийн байгууллагаас тусгай ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тодорхойлжээ.

- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд “Нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий байгууллага нь энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй.”⁶

- 14 дүгээр зүйлд “Жагсаал, цуглаан хийхийг бүртгэсэн, эсхүл харьяалах нутаг дэвсгэр дээр нь бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулагдаж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд бий болсон нөхцөл байдлыг жагсаал, цуглаан зохион байгуулагчид мэдэгдэж, 2 цагийн дотор түүнийг тараахыг бичгээр шаардана.”⁷ гэж тус тус заажээ.

Энэ хуульд зааснаар жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол жагсаал, цуглаан зохион байгуулагчид 2 цагийн дотор түүнийг тараахыг бичгээр шаардах ба жагсаал, цуглааныг сайн дураар тараахаас татгалзсан буюу татгалзаагүй боловч уг үйл ажиллагааг дурдсан хугацаа өнгөрсний дараа цаашид үргэлжлүүлбэл жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараахаар хуульчилсан байна.

Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд:

- “Хууль тогтоомж зөрчиж зохион байгуулсан жагсаал, цуглаан, олон нийтийн бусад арга хэмжээг хуульд заасан арга, хүч хэрэгслээр шууд албадан тараах.

- Нийтийн эмх замбараагүй байдал бий болгож хүч хэрэглэсэн үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа байгууллагыг тараах, бүлэг хүмүүсийг албадан тараах, албадан саатуулах, тэдгээрийн зэвсэг, техник хэрэгслийг хураан авах.

- Нийтийн эмх замбараагүй байдлыг арилгахад саад учруулж буй улс төрийн нам, эвсэл холбоо, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох”⁸ гэж заасан байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар бүлэг (39-46 дугаар зүйл)-т цагдаагийн байгууллага, алба хаагчийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх тухай заажээ.

Энэ хуульд цагдаагийн байгууллага, алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэлийг тодорхой зааж өгсөн байдаг. Тухайлбал: 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт үйлдлийг өөр арга, хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол цагдаагийн алба хаагч... галт зэвсэг хэрэглэж болно.”⁹ гэж заасан бол 42 дугаар зүйлд

⁵ Цагдаагийн албаны тухай хууль. 2013

⁶ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль.1994

⁷ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль. 1994

⁸ Онц байдлын тухай хууль 1995

⁹ Цагдаагийн байгууллагын тухай хууль. 1993

олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх талаар тусгасан байна. Энд зааснаар цагдаагийн алба хаагч дараах зорилгоор олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэнэ. Үүнд:

- Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох,
- Нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох,
- Байгууллага иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх,
- Хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг баривчлах,
- Цагдаагийн алба хаагчийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон,
- Цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа онц чухал объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэсэн буюу бүлэглэн довтолсон,
- Хүнийг барьцаанд авсан,
- Ялтан, баривчлагдсан, цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүн зугтсан,
- Галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн,
- Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон,
- Хорих, цагдан хорих, баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон,
- Цагдаагийн алба хаагчийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон гэсэн үндэслэлийг оруулсан байна.

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д “Нийгмийн хэв журам хамгаалах” код 400, “Жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журам хамгаалах” код 412, “Жагсаал, цуглааныг албадан тараах” код 413, “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед нийгмийн хэв журам хамгаалах” код 414, “Онц байдал зарласан үед нийгмийн хэв журам хамгаалах” код 416-д цагдаагийн байгууллага, алба хаагчаас гүйцэтгэх үүргийг тодорхойлон гаргасан байна.

Түүнчлэн “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх код 233”, “Галт зэвсэг хэрэглэх” код 234, “Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх” код 235, “Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх” код 236, “Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх” код 237, “Албаны нохой сургах, хэрэглэх” код 239, “Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэсэн талаар шалгалт явуулж, дүгнэлт хийх” код 240 зэрэг журмуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахаар заажээ.

Хүч хэрэглэхтэй холбоотой олон улсын хүний эрхийн хэм хэмжээ тогтоосон хууль эрхийн актуудад нэлээд олон хязгаарлалтуудыг тогтоосон ба аливаа улс орнуудын төрд хүний амьд явах, эрүү шүүлт болон бусад хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төрийг доромжилсон хандлага, эсвэл шийтгэлээс ангид байх эрхийг хүндэтгэх, хамгаалах үүрэгтэйг сануулахад чиглэсэн байдаг.

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д заасан хүний эрх, эрх чөлөөг бататгаж хангахад ихээхэн ач холбогдол бүхий “Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пакт”-ыг баталж, 1976 оноос хүчин төгөлдөр болон мөрдөгдөж байна.

Монгол Улс НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг

бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн гишүүн улс бөгөөд энэ конвенцид эрүү шүүлт болон бусад зүй бус харьцааг ямар ч нөхцөлд хориглосон байдгийг санах хэрэгтэй юм.

Монгол Улс 1993 онд болсон Дэлхийн хүний эрхийн бага хуралд оролцож, тус хурлаас гаргасан "Венийн тунхаглал" дахь "...улс гүрэн хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хамгаалах явдлыг тодорхой үе шаттайгаар сайжруулах, үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх" уриалгыг дэмжин хүлээн авсан бөгөөд Улсын Их Хурлаас 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний цогц эрх зүйн баримт бичиг болох "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна.¹⁰

Цагдаагийн байгууллагын ажилд шууд хамаарах олон улсын баримт бичгүүдэд "Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль", "Нийгмийн хэв журам сахиулах үүрэгтэй албан тушаалтан хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд" зэргийг дурьдаж болох юм.

Тулгамдаж буй асуудал

Цагдаагийн байгууллагын түүхэнд нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчсөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах ажлын туршлага төдий л олон биш бөгөөд 1982 оны "Хүнсний 20"-ийн үймээн, зодоон, "2008 оны 7 дугаар сарын 1"-ны жагсаал, цуглаанаар хязгаарлагддаг билээ. Энэ нь нийгмийн тогтолцоо, ард түмний амьдралын хэв маяг, зан заншил, ёс суртахуунтай холбоотой байсан юм.

Нэг талаас авч үзвэл, монгол хүний тайван амгалан зан төлөв байдлаас шалтгаалан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал анхаарал татах хэмжээнд гарч байгаагүй нь цагдаагийн байгууллагад түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх онол, практикын дадлага эзэмших тодорхой шаардлагыг бий болгоогүй байна.

Нөгөө талаас нь авч үзвэл, цагдаагийн байгууллагын өмнө ийм асуудал үүсвэл хэрхэн ажиллах талаарх онол, аргачлал, ажлын дадлага, туршлага зайлшгүй шаардлагатайг харуулсан юм. Цагдаагийн байгууллага энэ талаар ямар нэгэн ажил хийж байгаагүй гэвэл өрөөсгөл дүгнэлт болно.

Цагдаагийн төв байгууллага, Нийгмийн хэв журам хамгаалах албанаас нарийн төлөвлөлт, дадлага сургалтыг 1990-ээд оноос эхлэн удаа дараа, тогтмол хийж байсан билээ. Түүнчлэн Цагдаагийн байгууллагын тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг шинэчлэн гаргаж, алба хаагчдаар судлуулсан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гэсэн хэдий ч нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчсөн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах ажиллагаанд онол, судалгаа, дадлагын нэгдсэн ойлголт, тогтсон аргачлал үгүйлэгдсээр байна.

Сүүлийн жилүүдэд зохион байгуулсан сургалт, дадлагын үед хэрэглэж буй команд нэг утга санаатай боловч өөр өөрөөр нэрлэгдэж байгаагаас шалтгаалан алба хаагчид будлих, өгөгдсөн үүргийн хэрэгжилт удаашрах байдал ажиглагдаж байна. Жишээлбэл: Дадлага сургалт удирдаж буй алба хаагч "Аюул дээрээс", "Дээврийн хамгаалалт ав" гэсэн хоёр өөр команд өгөхөд бие бүрэлдэхүүн ойлгохгүй байх, эсвэл нэг л үйлдлийг гүйцэтгэж байна. Энэ нь командаа мэдэхгүй байгаа, буруу ойлгосон зэрэгтэй холбоотой юм.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах явцад цагдаагийн байгууллага, алба хаагч албаны тусгай хэрэгслийг буруу хэрэглэсэн гэх асуудал удаа дараа гардаг билээ. Энэ нь цагдаагийн байгууллага, алба хаагч хүний эрх, эрх чөлөөг хөндсөн үйл ажиллагаа явуулдагтай нь холбоотой боловч гагцхүү хуулийн хүрээнд явагдах ёстойг сануулсан анхааруулга, шаардлага гэж ойлгон хүлээн авч, хэрэгжүүлэхдээ мөрдөх хэрэгтэй юм.

¹⁰ Ш.Нарантуяа. Хүний эрх ба цагдаа. УБ., 2010.